



АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн (ХААХОУС) санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөлд (ЗЗБУХ) **Хяналт, үнэлгээний ажилтан** шалгаруулж авна.

ЗЗБУХ Төсөл нь бэлчээрийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хөдөөгийн бичил, жижиг бизнес эрхлэгчид, эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр 2018 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Төсөл нь Архангай, Дорнод, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн сонгогдсон 24 сумданд хэрэгждэг болно.

Ажилтан нь дараах үндсэн ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- ХААХОУС болон ХХААХҮЯ-ны шаардлагын дагуу төслийн хяналт, үнэлгээний системийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх,
- Төслийн логик хүрээний биелэлтийг хянаж, хэрэгжилтийн явц, үр дүн, хүндрэл бэрхшээлийн хянаж, гарцыг тодорхойлоход мэдээллээр хангах,
- Төслийн дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн систем болон цахим хуудсыг хариуцан, тогтмол ажиллагааг хангах,
- Төслийн нэгдсэн тайланг Англи, Монгол хэл дээр бэлтгэх.
- Гэрээгээр ажил гүйцэтгэгч байгууллагуудыг тайлан бэлтгэхэд нь тусалж тайлан бичих маягт, хугацаа, арга зүйг тодорхойлно. Үүнд, улирлын тайлан, жилийн тайлан, эцсийн тайлан, гэнэтийн шаардлагатай тайлан зэрэг багтана,
- Төслийн жилийн ажлын төсөв, төлөвлөгөөг нэгтгэн төслийн стратеги, зорилтуудыг тусгасан эсэхэд анхаарах, хяналт, үнэлгээний төлөвлөгөөг тусгах,
- Төслийн үр дүн, нөлөөллийг харуулах мэдээллийг цуглуулах, мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулах аргачлал, хариуцах албан тушаалтаныг тодорхойлж нэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийх. Төслийн үр дүнгийн болон бусад хяналт үнэлгээтэй холбогдох судалгаануудыг удирдан зохион байгуулах,
- Санхүүжүүлэгч байгууллагын жил тутмын Хяналт, үнэлгээний ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж, тайланг Англи, Монгол хэл дээр бэлтгэн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавих,

- Хяналт, үнэлгээний сургалтыг төслийн нэгж болон гэрээт байгууллагууд, түншлэгчид, орон нутгийн байгууллагууд, анхдагч түншлэгчдэд зохион байгуулах, улмаар орон нутаг дах хяналт, үнэлгээний талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах,
- Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгавар.

Тавигдах үндсэн шаардлага

- (a) Хөдөө аж ахуй, байгалийн нөөц, эдийн засаг, бизнесийн удирдлага чиглэлээр бакалавраас дээш зэрэгтэй,
- (b) Англи, Монгол хэлний ярианы болон бичгийн өндөр чадвартай,
- (c) Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх чадвартай,
- (d) Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны талаар бүрэн ойлголттой, түүний боловсронгуй болгох хэрэгжүүлж байсан туршлагатай,
- (e) Хяналт үнэлгээний цахим системийг ашиглаж байсан туршлагатай,
- (f) Төсөлд оролцогч талуудын эрэлт хэрэгцээг үнэлэх, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх чадавхтай,
- (g) Судалгаа тайланд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, баримт бичиг боловсруулах, хэвлэл мэдээлэлд материал бэлтгэх чадвартай,
- (h) Төрийн болон төрийн бус, хувийн хэвшил, эмзэг бүлгийн иргэдтай ажиллаж байсан туршлагатай, харилцааны өндөр чадвартай,
- (i) Олон улсын донор байгууллагын бодлого, журам, жендэр, байгаль орчин, авлига, төслийн удирдлага болон санхүүгийн талаар ерөнхий мэдлэгтэй,
- (j) Багаар ажиллах чадвартай байх.

Ажилд орох хүсэлт, холбогдох материалыг 2019 оны 9 сарын 26-ны өдрийн 17:30 цаг хүртэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 601 тоотод хүлээн авна.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет
- Дэлгэрэнгүй намтар
- Өргөдөл
- Холбогдох баримт бичгийн хуулбар (Их сургуулийн диплом, иргэний үнэмлэх)